

МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХУДАЛДАА АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМЫН ШАГНАЛЫН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 МҮХАҮТ-ын нэрэмжит шагнал нь Монгол Улсын үндэсний үйлдвэрлэлийг дэмжих, бичил, дунд бизнес болон ногоон эдийн засаг, ногоон бизнес, компанийн нийгмийн хариуцлагыг хөгжүүлэх, хувийн хэвшлийг дэмжихэд бодитой хувь нэмэр оруулж буй гадаад, дотоодын байгууллага, компани, аж ахуйн нэгж, хувь хүнийг урамшуулж, алдаршуулснаар Монгол улсын эдийн засгийн чадавхи, хөгжлийн хурдацыг дээшлүүлэхэд чиглэгдэнэ.

1.2 МҮХАҮТ-ын шагналыг Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын Даргын шийдвэрээр олгоно.

Хоёр. Шагнал олгох болзол

2.1 МҮХАҮТ-ын дээд шагнал **“ХИЙМОРЬ”** хүндэтгэлийн одонгоор Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжил дэвшил, Монгол Улсад хувийн хэвшил, бизнесийг хөгжүүлэх, үр ашгийг дээшлүүлэхэд томоохон хувь нэмэр оруулж бизнесийн салбарт өндөр үр ашигтай дэвшилтэт техник технологи нэвтрүүлэн 10-аас дээш жил ажиллаж тодорхой үр дүнд хүрсэн компани, аж ахуйн нэгж, хувь хүнийг шагнана. Шагналд нэр дэвшигдэх байгууллага, аж ахуйн нэгж, хувь хүн иргэд 10-аас доошгүй жил үр бүтээлтэй ажилласан байх шаардлагатай. Одонг 300.000 төгрөгийн мөнгөн шагнал дагалдах ба эх үүсвэрийг шагнагдаж буй байгууллага хариуцна

2.2 МҮХАҮТ-ын шагнал **“SILK ROAD”** хүндэтгэлийн одонгоор Монгол Улсын нийгэм, эдийн засгийн чадавхийг дээшлүүлэх, хувийн хэвшил, бизнесийн хөгжлийг өргөжүүлэн хөгжүүлэхэд онцгой хувь нэмэр оруулж буй гадаадын иргэд, гадаадын хөрөнгө оруулалттай компани, аж ахуйн нэгжийг шагнана.

2.3 МҮХАҮТ-ын **“БИЗНЕСИЙН ЭРХЭМСЭГ ОРШИХУЙ” - “BUSINESS EXCELLENCE AWARD”** -н шагналаар Монгол Улсын эдийн засгийн чадавхийг дээшлүүлэх, хувийн хэвшил, бизнесийг хөгжүүлэхэд олон жил бодитой хувь нэмэр оруулж буй дотоод, гадаадын аж ахуйн нэгж, компанийг шагнана.

2.4 МҮХАҮТ-ын **“ENTREPRENEURSHIP SPIRIT”** хүндэт тэмдэгээр Монгол Улсын нийгэм, эдийн засгийн чадавхийг дээшлүүлэх, хувийн хэвшил, бизнесийн хөгжлийг өргөжүүлэн хөгжүүлэхэд онцгой хувь нэмэр оруулж буй монголын бизнес эрхлэгчид болон гадаадын иргэдийг шагнана.

Хүндэт тэмдэгийг 100.000 төгрөгийн мөнгөн шагнал дагалдах ба эх үүсвэрийг шагнагдаж буй байгууллага хариуцна.

2.5 МҮХАҮТ-ын **“GREENPRENEUR”** хүндэт тэмдэгээр Монгол Улсад ногоон бизнес, ногоон эдийн засгийг хөгжүүлэхэд онцгой хувь нэмэр оруулж буй монголын бизнес эрхлэгчид болон гадаадын иргэдийг шагнаана.

Хүндэт тэмдэгийг 100.000 төгрөгийн мөнгөн шагнал дагалдах ба эх үүсвэрийг шагнагдаж буй байгууллага хариуцна.

2.6 МҮХАҮТ-ын **“КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ШАГНАЛ” - “CSR AWARD”** шагналаар Монгол Улсад компанийн нийгмийн хариуцлагыг хөгжүүлэх чиглэлээр онцгой үр бүтээлтэй ажиллаж буй дотоод, гадаадын компани, аж ахуйн нэгжүүдийг шагнаана.

2.7 МҮХАҮТ-ын **“ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЧӨЛӨӨ” - “ECONOMIC FREEDOM AWARD”** шагналаар Монгол Улсын нийгэм, эдийн засгийн чадавхийг дээшлүүлэх, хувийн хэвшил, бизнесийн хөгжлийг өргөжүүлэн хөгжүүлэхэд онцгой хувь нэмэр оруулж буй УИХ-ын гишүүд, төрийн албан хаагчдыг шагнаана.

2.8 МҮХАҮТ-ын **“САЙН ЗАСАГЛАЛЫГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ”** шагналаар бизнесийн орчныг тааламжтай болгох, төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хөгжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулж буй төрийн байгууллагууд, түүний удирдлагыг болон компанийн сайн засаглалын зарчмуудыг үйл ажиллагаандаа амжилттай хэрэгжүүлж буй дотоод, гадаадын байгууллага, компаниудыг шагнаана.

2.9 МҮХАҮТанхимын **“ҮНДЭСНИЙ БИЗНЕСИЙН МАНЛАЙЛАГЧ” - “NATIONAL BUSINESS CHAMPION”** шагналаар бизнесийн секторт он удаан жил онцгой үр бүтээлтэй ажиллаж, Монгол Улсын эдийн засгийн хөгжилд жинтэй хувь нэмэр оруулж буй үндэсний бизнесийн байгууллагуудыг шагнаана.

2.10 МҮХАҮТ-ын **ХҮНДЭТ ӨРГӨМЖЛӨЛ, ХҮНДЭТ ЖУУХ БИЧИГ** худалдаа, үйлдвэрлэл, бизнесийн чиглэлээр 3- 8 жил үр бүтээлтэй ажилласан хувийн хэвшлийн болон бизнесийн орчинг дэмжин ажилладаг төрийн ба төрийн бус байгууллагын ажилтнуудыг шагнаана. Хүндэт Өргөмжлөлийг 50.000 төгрөг, Хүндэт Жуух бичгийг 100.000 төгрөгийн мөнгөн шагнал дагалдах ба эх үүсвэрийг шагнагдаж буй байгууллага хариуцна.

2.11 МҮХАҮТ-ын **ХҮНДЭТ ГИШҮҮНИЙ ТЭМДЭГ** -ийг дүрмийн дагуу сонгогдсон бөгөөд тус танхимыг үүсгэн байгуулахад онцгой хүчин зүтгэл гаргаж, өргөжин хөгжихөд бодитой тус дэмжлэг үзүүлэн, нягт хамтран ажиллаж байсан тодорхой гавъяа бүхий Хүндэт гишүүдэд олгоно.

Гурав. Шагналд нэр дэвшүүлэх, тодорхойлох

3.1 Шагналд нэр дэвшигч нь энэхүү журмын 2 дугаар хэсэгт заасан болзлыг хангасан байна.

3.2 Шагналд нэр дэвшүүлэх санаачилгыг мэргэжлийн холбоо, зөвлөлүүд, танхимын салбар зөвлөлүүд, нэр дэвшигчийн ажиллаж буй үндсэн байгууллага гаргах бөгөөд шагналд нэр дэвшигчийн үйл ажиллагааны болон ажлын үр дүнгийн талаар тодорхойлолт ирүүлнэ. Тодорхойлолтод шагнуулах үндэслэл, ажлын

амжилтыг үнэн зөв, товч тодорхой тусгаж холбогдох тооцоо судалгааг хавсаргасан байна.

3.3 Шагналд нэр дэвшигчийн тодорхойлолтод мэргэжлийн холбоод, салбар зөвлөлүүд, нэр дэвшигчийн ажиллаж буй үндсэн байгууллагын удирдлага гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулна.

3.4 Энэхүү журмын 2.3- 2.9, 2.11-д заагдсан шагналыг МҮХАҮТ-ын саналыг үндэслэн олгоно.

3.5 Шагналд нэр дэвшигч дараах материалыг бүрдүүлнэ.

Үүнд:

- Байгууллагын албан тоот
- Нэр дэвшигчийн анкет
- Нэр дэвшигчийн ажил байдлын тодорхойлол /Байгууллага бол үйл ажиллагааны танилцуулга/
- Хамт олны хурлын протокол

Дөрөв. Шагнах асуудлыг хянан шийдвэрлэх

4.1 Шагнуулахаар ирүүлсэн материалыг танхимын Ерөнхий нарийн бичгийн дарга хүлээн авч бүртгэн, танхимын Даргад танилцуулан шийдвэрлүүлнэ.

4.2 Шагнагдаж буй компани, аж ахуйн нэгж нь тухайн шагналын хураамжийг доор дурдсан үнэлгээний дагуу МҮХАҮТ-ын дансанд тушаасан байна.

Үүнд:

1. "Хийморь" одон - 30.000 төгрөг
2. "Silk Road" одон - 30.000 төгрөг
3. Бизнесийн эрхэмсэг оршихуйн шагнал "Business Excellence Award" - 55.000 төгрөг
4. Хүндэт тэмдэг "Entrepreneurship Spirit" , "Greenpreneur" - 15.000 төгрөг
5. Компанийн нийгмийн хариуцлагын шагнал "CSR Award" - 30.000 төгрөг
6. Эдийн засгийн эрх чөлөөний шагнал "Economic Freedom Award" - 30.000 төгрөг
7. "Сайн засаглалыг хэрэгжүүлэгч" шагнал - 30.000 төгрөг
8. Үндэсний бизнесийн манлайлагч "National Business Champion Award" - 30.000 төгрөг
9. МҮХАҮТ-ын Хүндэт Жуух - 10.000 төгрөг
10. МҮХАҮТ-ын Хүндэт Өргөмжлөл - 8.000 төгрөг

**МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХУДАЛДАА АЖ ҮЙЛДВЭРИЙН
ТАНХИМЫН ШАГНАЛД НЭР ДЭВШИГЧИЙН АНКЕТ**

1. Овог:
2. Нэр:
3. Төрсөн огноо:
4. Хүйс:
5. Төрсөн аймаг, сум, хот:
6. Одоогийн харъяалал:
7. Нийгмийн байдал:
8. Регистрийн дугаар:
9. Боловсрол:
10. Ажилладаг салбар:
11. Мэргэжил:
12. Урьд ажиллаж байсан, одоо ажиллаж байгаа аж ахуйн нэгж, байгууллага:
- 13.

№	Ажлын байрны нэр	хугацаа	Эрхэлсэн ажил

14. Урьд шагнагдаж байсан байдал:

№	Шагналын нэр	Шагнагдсан он

15. Шагнуулах үндэслэл:
.....
16. Ямар шагналаар шагнуулах:
17. Хамт олны хурлын саналын хувь:

Жич: Шагналын материалд анкетын хамт нэр дэвшигчийн ажил байдлын тодорхойлолт, олны хурлын тэмдэглэлийг хавсаргасан байна.

МАНССГ